



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

**Дотоод аудитын албанаас хяналт,  
шалгалт явуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас 2018 онд 32 байгууллагад дотоод аудит, хяналт, шалгалт зохион байгуулсугай.

2. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудад дотоод аудит, хяналт шалгалт явуулах 2018 оны хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дотоод аудит, хяналт, шалгалт хийх удирдамжийг тухай бүр боловсруулан батлуулж ажилласугай.

4. Дотоод аудит, хяналт, шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу явуулж дүгнэлт, зөвлөмж гарган, үр дүнг тайлагнаж ажиллахыг Дотоод аудитын алба /Б.Туяа/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА